

Техникийн дүгнэлт гаргах  
комиссын ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “УБДС” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй машин механизм, шугам хоолой, дулаанжуулалтын тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хариуцаж буй харьяалах албан тушаалтнуудаар бүрэн хангуулах, гарсан аваар саатал доголдлын шалтгааныг судлах, үүссэн хохирлын хэмжээг тогтоох, техникийн дүгнэлтийг гаргаж акт тогтоох, учруулсан хохиролыг барагдуулах, компанийн удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэх, хэвийн болгох арга хэмжээг зохион байгуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Компанийн техник, технологи үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд саатал учруулахуйц тоног төхөөрөмж техник хангамжийн хэрэгслийн томоохон гэмтэл, доголдол зэрэг хохирлуудад тухай бүрд нь Техникийн дүгнэлт гаргах комисс хуралдаж, протокол үйлдэн акт тогтооно.

2.2. Ашиглалтын явцад гарсан, тоног төхөөрөмж машин механизм болон түүний эд ангиудын эвдрэл гэмтэл сааталтай холбоотой мэдүүлэг, видео бичлэг, фото зураг болон холбогдох баримтуудыг Техникийн дүгнэлт гаргах комиссын актанд хавсаргана.

2.3. Ашиглалтын явцад гарсан саатлын улмаас гарсан хохирлын хэмжээг Техник хяналт, дотоод аудитын албаны Дамжуулах сүлжээний техник хяналт, ашиглалтын байцаагч инженер, тухайн зөрчилтэй холбогдох албадын инженер техникийн ажилтнууд хамтран судлах ба Инженерийн алба нь үзүүлэлт тус бүрээр /алдагдсан дулааны эрчим хүч, нэмэлт усны алдагдал, борлуулалтын орлогын тасалдал, дагалдан гарсан хохирлууд гэх мэт/ тооцож, актанд тусгасан байна.

2.4. Актанд тусгагдсан зөрчил, доголдолтой холбогдох ажиллагсдын зөрчил, дутагдлыг тухайн албаны удирдлагууд Техникийн дүгнэлт гаргах комисстой хамтран тогтоож, доголдол зөрчлийн мөрөөр хийгдэх ажлын жагсаалтыг гаргаж хэвийн болгох арга хэмжээ авна.

2.5. Эвдрэл гэмтэл, гарсан тоног төхөөрөмжийн гэмтлийг засварлах, хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хангах ажилд, уг тоноглолыг хариуцсан албаны холбогдох инженер техникийн ажилтан болон засварчид хяналт тавина.

2.6. Аваар, саатал, зөрчил, доголдлын ангилал, хохирлын хэмжээ, холбогдох буруутанд хүлээлгэх хариуцлагыг Техникийн дүгнэлт гаргах комисс тогтооно.

2.7. Техникийн саатал зөрчлийн мөрөөр авах зохион байгуулалтын арга хэмжээг биелэгдэх бодит нөхцлөөр тогтоож, хариуцах эзэн, гүйцэтгэх хугацаа зэргийг тодорхой заасан хөтөлбөрийг батлуулан актанд хавсаргасан байна.

2.8. Эвдрэл доголдол гарсан тоног төхөөрөмж, шугам хоолой, эд ангиудын засварыг харьяалах албаны холбогдох ажилтнууд бүрэн хийж гүйцэтгэсний дараа ажиллагаанд залгах зөвшөөрлийг Ерөнхий инженерийн шийдвэрийг үндэслэн Шуурхай удирдлага тохируулгын албаны дарга болон ээлжийн диспетчер инженерүүд олгоно.

2.9. Энэ тухай шуурхай ажиллагааны журналд тодорхой бичиж, баримтжуулсан байна.

#### Гурав. Техникийн дүгнэлт гаргах комиссын бүрэлдэхүүн, ажиллах чиглэл

3.1. Техникийн дүгнэлт гаргах комиссын бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилох бөгөөд тухайн зөрчил, доголдол гарсан албаны дарга, инженер техникийн ажилтнууд хамтарсан байдлаар оролцоно.

3.2. Техникийн дүгнэлт гаргах комисс нь нотлох баримтад тулгуурлан шийдвэр гаргана.

3.3. Баримтад доорх зүйлүүд хамаарна. Үүнд:

- Аваари, саатал, гэмтэл гарсан тоноглолын техникийн бичиг баримт, түүний хөтлөлт
- Шаардлагатай схем, зураг, техникийн тодорхойлолтууд
- Гэмтэл саатал гарсан үеийн горим ажиллагааны хөтлөлт
- Шалгасан комиссын дүгнэлт
- Холбогдох ажилтнуудтай уулзаж ярилцсан тэмдэглэл, протоколууд болон мэдүүлгийг бичгээр авсан баримт
- Сүлжээний параметрийн мэдээ
- Түр хязгаарласан дулааны эрчим хүчний тооцоо

#### Дөрөв. Акт тогтоох

4.1. Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон техникийн дүгнэлт гаргах комисс нь зөрчил, доголдлын хохирлыг тогтоохдоо тухайн тоног төхөөрөмж, машин механизмын сул зогссон хугацаа, сул зогсолтын хугацаанд тасалдсан үйлдвэрлэлийн үйл ажиллагааны саатлын тоо хэмжээ, хэвийн болгох үйл ажиллагаанд зарцуулсан сэлбэг материал, ажилласан хүн хүч, машин механизмын зардал зэрэг хохирлыг үндэслэн хурлын шийдвэрээр буруутай алба, албан тушаалтанд акт тогтооно.

4.2. Техникийн комиссын дүгнэлт болон тогтоосон актны талаар салбар, албаны буруутай албан тушаалтанд урьдчилан мэдэгдэнэ.

4.3. Актыг эс зөвшөөрвөл буруутай этгээд шүүхийн байгууллагаар асуудлыг шийдвэрлүүлэх эрхтэй.

## Тав. Бусад

5.1. Техникийн дүгнэлт гаргах комиссын хурлын шийдвэр дүгнэлтийг үндэслэн уг тоног төхөөрөмжийг шинэчилэн солих их ба урсгал засварт оруулах талаар засварын ажлын төлөвлөгөөнд тусгаж цаашид хэвийн үйл ажиллагааг хангахад бүрэн хариуцлага хүлээнэ.

5.2. Техникийн дүгнэлт гаргах комиссын шийдвэр нь техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.